

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ ХОРИНХОЁРДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2017 оны аравдугаар сарын 26-ны 12 цаг 20 минутад эхэлж, 13 цаг 25 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д 1 цаг 05 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах Комиссын танилцуулга /Удирдах албан тушаалд томилогдох нээлттэй сонгон шалгаруулалтын дүн, тайлан/	
2	Дундговь аймгийн Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэр, Сонгон шалгаруулах комиссын 2017 оны НСШ/32 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн: 1. Цэндийн Эрдэнэсүрэн, Гомбын Уянга нарыг Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх. 2. Цэндийн Эрдэнэсүрэнг Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Дундговь аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.
3	Сүхбаатар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар

<p>ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэр, Сонгон шалгаруулах комиссын 2017 оны НСШ/33 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн:</p> <p>1. Адъяагийн Чулуунбат, Чадраавалын Эрдэнэбилэгт нарыг Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх</p> <p>2. Адъяагийн Чулуунбатыг Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Б.Мөнхбат/-д санал болгох Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
---	---

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА**